



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Булган аймаг)

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	
3		
2	Аудитын тайлан	
5		
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	Error! Bookmark not defined.
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	
11		
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
		Error! Bookmark not defined.

1 Аудитын гэрчилгээ


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Г БУЛГАН АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ДАРГА О.НАРАНЖАРГАЛ ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020-02-27 № 88

танай _____ -ны № _____ т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заасны дагуу Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Аймгийн ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 20.3 сая төгрөгийг зарцуулсан, хувь хүмүүсээс авах 25.3 сая төгрөгийн

006020177

авлагыг барагдуулаагүй, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зориулалт бус 30.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, байгууллагын дотоод журам зөрчин 4.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон зэрэг нийт 80.5 сая төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Булган аймгийн ЗДТГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга О.Наранжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.20-наас 2020.02.27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь төрийн аудитын газар-ын П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн ЗДТГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т -ны өдрийн дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Булган аймгийн ЗДТГ нь Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны удирдлагыг тасралтгүй хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжихэд оршино.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаанд дараах зарчмыг эрхэмлэнэ.

Үүнд: Зөвлөгөө дэмжлэг нь

- Өндөр мэргэшлийн
- Цаг үеэ олсон
- Шуурхай байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "" программ хангамж ашигладаг байна.

дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 26 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь холбоотой юм.

2019 оны *Нийт зардал* 68,846.30 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 68,846.30 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь 2 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 20 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав. Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	51,731,323.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,760,663.00	
3	Албан шаардлага өгсөн	2	34,909,264.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	10	88,401,250.00	

2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.5 Зардлын данстай холбоотой асуудал

Аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/75 дугаар тушаалаар улирлын үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг дарга З.Батзоригт 787453, Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзийд 486605, Засаг даргын орлогч О.Гантулгад 486605 төгрөгийг олгосон

Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйл тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоосон.

2.8.1.6 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Эрдмийн өргөө цогцолбор сургуульд тоног төхөөрөмж техник хэрэгсэл худалдаж авахад дэмжлэг үзүүлэхэд 5000000, Прокурорын газарт авто машин худалдан авахад 10000000, Хутаг-Өндөр сумын "Гуртын гүүр"-ийн мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын хэсгийн албаны хэрэгцээнд авто машин авахад 10000000, Цагдаагийн газар авто машин авахад дэмжлэг 5000000 төгрөгийг тус тус зарцуулсан нь Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2 дахь "Засаг даргын нөөц хөрөнгийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно", 2.2.1.2 дахь "Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2 дахь "Засаг даргын нөөц хөрөнгийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно", 2.2.1.2 дахь "Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Давтан гаргахгүй байх, албан шаардлага өгсөн.

2.8.1.7 Зардлын данстай холбоотой асуудал

Засаг даргын 2013 оны А/11 дүгээр захирамжаар баталсан байгууллагын дотоод журмын 6.2.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг дарга З.Батзоригт 566965, Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзийд 1751778, ХОХБТ хэлтсийн мэргэжилтэн Д.Нарангэрэл 1422291, Э.Эрболдод 1168230, төгрөгийг тэтгэмж олгосон байна.

Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын 5.1 дэх " Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосны улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт

хугацаанд нөхөн олгоно.", Байгууллагын дотоод журмын 6.2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Давтан гаргахгүй байх, албан шаардлага өгсөн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орлогын данстай холбоотой

3.1.1 Илрүүлэлт: Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 8000000 төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 13019050 төгрөгийн орлого орж 5019050 төгрөгөөр давж биелсэн нь зориулалт бус зардал гарах, батлагдсан төсөв хэтрэх зэрэг эрсдэл байна.

3.1.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах

3.1.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогыг бодиттой тооцоо судалгаанд үндэслэн бүрэн төлөвлөж, батлуулж байх.

3.1.4 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2 Байгууллагын дотоод журамтай холбоотой

3.2.1 Илрүүлэлт: Байгууллагын дотоод журмыг аймгийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/11 дүгээр захирамжаар баталсныг Төрийн албаны болон бусад хууль тогтоомж шинэчлэн гарсантай холбоотой өөрчлөлтүүд хийгээгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх "Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл: Хууль, дүрэм, журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.2.3 Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.3 НББ-ийн бодлогын бичиг баримт

3.3.1 Илрүүлэлт: НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, бодлогын бичиг баримтгүй байна.

3.3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль журам зөрчигдөх.

3.3.3 НББ-ийн тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллан өөрийн үйл ажиллагааны онцлогт, хууль, стандарт, дүрэм, журамд нийцсэн НББ-ийн бодлогын бичиг баримтыг боловсруулан баталж мөрдөн ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.4 Хөрөнгөтэй холбоотой

3.4.1 Илрүүлэлт: Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг нь тооллого явуулсан ч ажлын тайлан, тооллогын материалыг Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтын дагуу бэлтгээгүй, тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль журам зөрчигдөх.

3.4.3 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, тооллогын бүртгэлийг батлагдсан маягт зааврын дагуу бэлтгэж, тооллого хийсэн ажлын тайланг хэлэлцэн баталж хэвших.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.5 Авлагын данстай холбоотой

3.5.1 Илрүүлэлт: ЗДТГ-ын орон сууцыг 2012 онд худалдсанаас үүссэн 8 жилийн насжилттай хувь хүмүүсээс авах авлагын 25340000 төгрөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.5.2 Эрсдэл: Хууль журам зөрчигдөх.

3.5.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.6 Өглөгийн данстай холбоотой

3.6.1 Илрүүлэлт: Аймаг байгуулагдсаны 80-н жилийн ойн хандивын орлогын үлдэгдэл 20332273.41 төгрөгийг өглөгт тусгаагүй өмнөх оны дутуу ажлын санхүүжилтэд зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл: Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулан санхүүгийн тайланд авлага, өглөгийг бүрэн тусгаж байх.

3.6.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах, насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.7 Хууль, журмын хэрэгжилт

3.7.1 Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны Б/04, Б/24, Б/64 тоот тушаалууд нь хүчингүй болсон Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн 4 албан хаагчид шагналын дагалдах мөнгө олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дахь "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх

3.7.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, шинээр гарч буй хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>148,606,817.82</u>	<u>157,838,969.33</u>
33	АВЛАГА	92,661,923.06	107,494,131.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	500,000.00
335	Бусад авлага	92,661,923.06	106,994,131.57
3351	Байгууллагаас авах авлага	67,321,923.06	81,654,131.57
3352	Хувь хүмүүсээс авах авлага	25,340,000.00	25,340,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	55,944,894.76	50,344,837.76
351	Түүхий эд материал	22,850,857.00	16,262,000.00
35110	Тусгай зориулалттай материал	22,850,857.00	16,262,000.00
354	Хангамжийн материал	33,094,037.76	34,082,837.76
35410	Бичиг хэргийн материал	80,000.00	1,190,000.00
35420	Аж ахуйн материал	29,271,987.76	31,550,787.76
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	3,660,000.00	1,260,000.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	00.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	82,050.00	82,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,613,594,580.92</u>	<u>5,518,624,612.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,613,594,580.92	5,518,624,612.88
392	Биет хөрөнгө	5,478,316,580.92	5,382,284,112.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,282,635,634.93	5,317,296,794.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-152,155,881.90	-258,131,926.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,400,000.00	354,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-274,755,555.42	-305,988,889.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	258,906,680.58	293,688,910.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-169,089,527.80	-200,197,080.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	224,536,454.28	252,042,254.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	-102,522,604.87	-122,243,351.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,327,770.00	59,327,770.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,966,388.88	-7,910,369.68
393	Биет бус хөрөнгө	135,278,000.00	136,340,500.00
39301	Програм хангамж	3,300,000.00	4,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,300,000.00	-3,737,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	169,487,600.00	169,487,600.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-34,209,600.00	-34,209,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,762,201,398.74</u>	<u>5,676,463,582.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>81,513,629.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	81,513,629.00
413	Өглөг	00.00	81,513,629.00
4136	Бусад өглөг	00.00	81,513,629.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	81,513,629.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,762,201,398.74</u>	<u>5,594,949,953.20</u>

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51	Засгийн газрын хувь оролцоо	5,762,201,398.74	5,594,949,953.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,104,006,679.64	1,104,006,679.64
51101	Өмч: - төрийн	1,104,006,679.64	1,104,006,679.64
512	Хуримтлагдсан үр дүн	3,663,938,392.67	3,496,686,947.13
51210	Өмнөх үеийн үр дүн	3,663,938,392.67	3,663,938,392.67
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-167,251,445.54
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	994,256,326.43	994,256,326.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,762,201,398.74	5,676,463,582.21

Үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,088,063,396.13	3,275,063,461.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,338,508,458.13	20,149,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,290,163,374.72	20,149,450.00
120003	Торгуулийн орлого	00.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,275,658,357.72	20,149,450.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,196,000.00	10,019,050.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,261,462,357.72	10,130,400.00
120009	Бусад орлого	14,505,017.00	00.00
122	Тусламжийн орлого	48,345,083.41	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	48,345,083.41	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,639,554,938.00	3,254,914,011.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,460,786,938.00	532,186,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,440,699,100.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	953,746,200.00	532,186,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	50,000,000.00	00.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	16,341,638.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	110,000,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,768,000.00	900,669,611.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,000,000.00	365,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,768,000.00	29,169,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	506,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	1,822,058,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,822,058,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	150,000,000.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	150,000,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,709,607,758.64	3,418,253,108.16

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,709,607,758.64	3,418,253,108.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,589,621,275.91	3,240,070,541.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,348,410.02	842,309,655.00
210101	Үндсэн цалин	408,455,582.85	464,313,461.00
210102	Нэмэгдэл	151,658,400.00	200,180,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,880,500.00	24,900,000.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	159,353,927.17	152,915,894.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,679,418.40	100,094,049.99
210201	Тэтгэврийн даатгал	62,366,488.41	67,289,249.99
210202	Тэтгэмжийн даатгал	6,600,050.43	8,201,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,280,040.54	6,561,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,278,427.28	1,640,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,154,411.74	16,402,400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,247,803.00	222,429,400.00
210301	Гэрэл, цахилгаан	10,201,096.00	9,995,000.00
210302	Түлш, халаалт	201,662,063.00	201,634,400.00
210303	Цэвэр, бохир ус	10,384,644.00	10,800,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,862,873.00	103,832,850.00
210401	Бичиг хэрэг	12,678,450.00	13,014,700.00
210402	Тээвэр, шатахуун	66,380,000.00	70,502,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,145,921.00	15,570,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,033,450.00	4,685,850.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	1,625,052.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	792,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	792,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,327,842.00	123,499,656.53
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	721,965.00
210602	Тавилга	00.00	265,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	89,327,842.00	122,512,691.53
2107	Томилолт, зочны зардал	56,190,881.00	110,430,800.00
210701	Гадаад албан томилолт	31,655,981.00	46,326,900.00
210702	Дотоод албан томилолт	24,534,900.00	64,103,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,109,634.00	830,035,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,051,195.00	823,006,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	456,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,736,400.00	3,558,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	419,575.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,474,500.00
210807	Газрын төлбөр	138,039.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,134,854,414.49	906,645,985.25

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,028,094,445.60	682,143,265.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,840,000.00	22,806,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,919,968.89	201,696,199.66
212	ТАТААС	5,000,000.00	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,000,000.00	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,986,482.73	178,182,566.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,362,540.00	118,287,113.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,982,028.00	50,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,380,512.00	53,249,834.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	15,037,279.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,623,942.73	59,895,452.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,623,942.73	59,895,452.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,378,455,637.49	-143,189,647.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	407,887,343.16	24,061,798.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,117,700.16	24,061,798.38
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	405,769,643.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-407,887,343.16	-24,061,798.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,970,568,294.33	-167,251,445.54

Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,828,274,228.41	3,314,067,107.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,719,290.41	10,019,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,374,207.00	10,019,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,196,000.00	10,019,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,196,000.00	10,019,050.00
120009	Бусад орлого	16,178,207.00	00.00
122	Тусламжийн орлого	48,345,083.41	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	48,345,083.41	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,749,554,938.00	3,304,048,057.41
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,444,445,300.00	532,186,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,440,699,100.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	953,746,200.00	532,186,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	50,000,000.00	00.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	16,341,638.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	110,000,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,768,000.00	949,803,657.41
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	49,134,046.41

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,000,000.00	365,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,768,000.00	29,169,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	506,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,000,000.00	1,822,058,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	1,822,058,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	150,000,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,693,489,656.41	3,192,609,477.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,693,489,656.41	3,192,609,477.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,524,369,128.07	2,932,913,282.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	747,375,826.67	834,720,294.00
210101	Үндсэн цалин	411,482,999.50	458,424,100.00
210102	Нэмэгдэл	151,658,400.00	199,680,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,880,500.00	24,900,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	159,353,927.17	151,715,894.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,679,418.40	104,296,497.00
210201	Тэтгэврийн даатгал	53,954,105.40	71,491,697.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,327,800.00	8,201,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,862,200.00	6,561,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,070,750.00	1,640,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,464,563.00	16,402,400.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,247,803.00	222,429,400.00
210301	Гэрэл, цахилгаан	10,201,096.00	9,995,000.00
210302	Түлш, халаалт	201,662,063.00	201,634,400.00
210303	Цэвэр, бохир ус	10,384,644.00	10,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	101,396,271.00	102,519,300.00
210401	Бичиг хэрэг	10,653,400.00	14,233,000.00
210402	Тээвэр, шатахуун	68,500,000.00	68,102,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,295,921.00	15,670,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,946,950.00	4,454,000.00
2105	Нормативт зардал	00.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,325,032.00	125,231,316.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,998,570.00
210602	Тавилга	00.00	265,000.00
210604	Урсгал засвар	89,325,032.00	122,967,746.00
2107	Томилолт, зочны зардал	55,728,181.00	110,930,800.00

Булган аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210701	Гадаад албан томилолт	31,655,981.00	46,326,900.00
210702	Дотоод албан томилолт	24,072,200.00	64,603,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,729,634.00	826,415,995.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,671,195.00	819,386,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	456,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,736,400.00	3,558,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	419,575.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,474,500.00
210807	Газрын төлбөр	138,039.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,062,886,962.00	605,569,680.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,054,996,962.00	581,920,619.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,890,000.00	23,649,060.41
212	ТАТААС	5,000,000.00	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,000,000.00	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,120,528.34	259,696,195.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,362,539.20	118,287,113.70
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,982,027.20	50,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,380,512.00	53,249,834.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	15,037,279.70
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	88,757,989.14	141,409,081.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,757,989.14	141,409,081.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>134,784,572.00</u>	<u>121,457,630.02</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	134,784,572.00	121,457,630.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	134,784,572.00	121,457,630.00
2200	Дотоод эх үүсвэрээр	134,784,572.00	121,457,630.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	134,784,572.00	121,457,630.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-134,784,572.00</u>	<u>-121,457,630.00</u>
250005	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00